



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: АРА-2025/002/НА-СТА-ЗГТС

<p>Цахим хуудас: <a href="http://www.open.audit.mn">www.open.audit.mn</a> Архангай аймаг 2024 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatar@audit.gov.mn Аудитор Л.Соёлмөнх Утас: 7033-3019 Цахим хаяг: Soyolmunkhl@audit.gov.mn</p>
--	--

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,  
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,  
Утас/Факс: (976) 7033 3141,  
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2025.03.26 № 172  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН  
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Д.ГЭРЭЛЧИМЭГ ТАНАА

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Архангай аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

Аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2024 оны тайланг Төсвийн тухай хуульд заасан цаглаварт хугацаанд ирүүлээгүйгээс санхүүгийн тайланд тусгагдсан 135,911,737.1 мянган төгрөгийн зардлыг үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхэд аудитын хангалттай зохистой нотолгоо олж авах боломжгүй байна.

Дээрх зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа буюу нийт дүнгээр санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8.9.2, 15.4.1, 16.5.7 дахь заалтыг зөрчсөн, бөгөөд санхүүгийн тайлагналын тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### Аудитын гол асуудал

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгыг Улсын их хурлаас 2023 онд баталж 2024 оны 01 дүгээр сараас эхэлж хэрэгжүүлсэн байна.

Аймгийн Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг 2024 онд нийт 138,860,305.8 мянган төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 135,887,422.9 мянган төгрөгийг зарцуулсан байна.

### Бусад асуудлын хэсэг

Тайлант онд даатгалын сангийн шинэ систем (Sicos.ndaatgal.mn)-ийг нэвтрүүлсэнтэй холбоотой арилжааны банк дахь 148 харилцах дансыг хааж, 16 дансаар тэтгэвэр, тэтгэмжийг олголтыг хийсэн байна.

*Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.*

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>10,146,341.79</b>	<b>11,824,959.85</b>
31	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>8,658,671.78</b>	<b>10,412,757.89</b>
31200	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>8,658,671.78</b>	<b>10,412,757.89</b>
31210	<b>Төгрөг</b>	<b>8,658,671.78</b>	<b>10,412,757.89</b>
31211	Төрийн сангийн харилцах	8,864.09	0.00
31213	Арилжааны банк дахь харилцах	8,649,807.69	10,412,757.89
33	<b>АВЛАГА</b>	<b>1,487,670.01</b>	<b>1,412,201.96</b>
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	74,910.98	310,185.66
33300	Татаас, санхүүжилтийн авлага	577,065.14	563,090.80
33500	<b>Бусад авлага</b>	<b>835,693.89</b>	<b>538,925.50</b>
33510	Байгууллагаас авах авлага	835,693.89	538,925.50
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>10,146,341.79</b>	<b>11,824,959.85</b>
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>473,439.13</b>	<b>1,642,942.00</b>
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>473,439.13</b>	<b>1,642,942.00</b>
41300	<b>Өглөг</b>	<b>19,768.06</b>	<b>201,436.31</b>
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	19,768.06	201,436.31
41400	<b>Урьдчилж орсон орлого</b>	<b>453,671.07</b>	<b>1,441,505.70</b>
41410	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	453,671.07	1,441,505.70
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>9,672,902.66</b>	<b>10,182,017.85</b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>9,672,902.66</b>	<b>10,182,017.85</b>
51200	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>9,672,902.66</b>	<b>10,182,017.85</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	9,507,020.09	9,672,902.66
51220	Тайлант үеийн үр дүн	165,882.57	509,115.19
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>10,146,341.79</b>	<b>11,824,959.85</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ Мянган төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>185,256,837.99</b>	<b>177,237,290.92</b>
11	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>34,565,048.44</b>	<b>40,541,356.21</b>
112	<b>Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого</b>	<b>34,565,048.44</b>	<b>40,541,356.21</b>
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	24,187,026.74	32,812,754.70
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2,508,973.60	3,563,107.73
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,417,400.51	3,018,322.07
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	459,362.32	1,147,171.71
112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	5,992,285.26	0.00
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>323,536.54</b>	<b>156,376.65</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>323,536.54</b>	<b>156,376.65</b>
120002	Хүүгийн орлого	43,908.52	57,066.94
120003	Торгуулийн орлого	0.00	2,752.20
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>37,903.05</b>	<b>0.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	37,903.05	0.00
120009	Бусад орлого	241,724.97	96,557.51
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>150,368,253.01</b>	<b>136,539,558.06</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>9,868,908.20</b>	<b>20,452,729.08</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	9,868,908.20	20,452,729.08
1330	<b>Төсвийн захирагчдаас</b>	<b>140,499,344.81</b>	<b>116,086,828.98</b>

Архангай аймгийн Нийгмийн даатгалын сангийн  
2024 оны санхүүгийн тайлан, гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	140,499,344.81	116,086,828.98
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>185,090,955.41</b>	<b>176,728,175.73</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>185,090,955.41</b>	<b>176,728,175.73</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>8,313.36</b>	<b>14,536.54</b>
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>8,313.36</b>	<b>14,536.54</b>
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	8,313.36	14,536.54
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>185,082,642.05</b>	<b>176,713,639.19</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>107,454,856.42</b>	<b>135,911,737.06</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	107,454,856.42	135,911,737.06
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>77,627,785.64</b>	<b>40,801,902.13</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	77,627,785.64	40,801,902.13
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>165,882.57</b>	<b>509,115.19</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>165,882.57</b>	<b>509,115.19</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ Мянган төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>186,054,281.70</b>	<b>177,237,290.92</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>34,672,035.45</b>	<b>40,541,356.21</b>
<b>112</b>	<b>Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого</b>	<b>34,672,035.45</b>	<b>40,541,356.21</b>
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	24,263,238.81	32,812,754.70
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2,515,634.92	3,563,107.73
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,423,584.47	3,018,322.07
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	459,811.61	1,147,171.71
112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	6,009,765.64	0.00
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>597,799.94</b>	<b>156,376.65</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>597,799.94</b>	<b>156,376.65</b>
120002	Хүүгийн орлого	43,908.52	57,066.94
120003	Торгуулийн орлого	0.00	2,752.20
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>553,891.42</b>	<b>96,557.51</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	553,891.42	96,557.51
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>150,784,446.31</b>	<b>136,539,558.06</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>10,285,101.50</b>	<b>20,452,729.08</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	10,285,101.50	20,452,729.08
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	<b>140,499,344.81</b>	<b>116,086,828.98</b>
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	140,499,344.81	116,086,828.98
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>185,131,180.52</b>	<b>175,483,204.81</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>185,131,180.52</b>	<b>175,483,204.81</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>8,313.36</b>	<b>14,536.54</b>
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>8,313.36</b>	<b>14,536.54</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	4,964.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	8,313.36	9,572.54
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>185,122,867.16</b>	<b>175,468,668.27</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>107,495,081.52</b>	<b>135,872,886.33</b>

Архангай аймгийн Нийгмийн даатгалын сангийн  
2024 оны санхүүгийн тайлан, гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	107,440,416.82	135,872,886.33
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	54,664.70	0.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>77,627,785.64</b>	<b>39,595,781.95</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	77,627,785.64	39,595,781.95
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>923,101,179.51</b>	<b>1,754,086.11</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>923,101,179.51</b>	<b>1,754,086.11</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	7,735,570.60	8,658,671.78
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	8,658,671.78	10,412,757.89

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/Мянган төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,507,020.09	9,507,020.09
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	9,507,020.09	9,507,020.09
9	Тайлант үеийн үр дүн	165,882.57	165,882.57
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,672,902.66	9,672,902.66
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	9,672,902.66	9,672,902.66
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	9,672,902.66	9,672,902.66
19	Тайлант үеийн үр дүн	509,115.19	509,115.19
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	10,182,017.85	10,182,017.85

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ Мянган төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>138,860,305.80</b>	<b>135,887,422.87</b>	<b>2,972,882.93</b>	<b>97.86</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	138,860,305.80	135,887,422.87	2,972,882.93	97.86
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	17,341.10	14,536.54	2,804.56	83.83
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,341.10	14,536.54	2,804.56	83.83
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,903.30	4,964.00	2,939.30	62.81
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	9,437.80	9,572.54	(134.74)	101.43
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	138,842,964.70	135,872,886.33	2,970,078.37	97.86
2132	Бусад урсгал шилжүүлэг	138,842,964.70	135,872,886.33	2,970,078.37	97.86
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	138,842,964.70	135,872,886.33	2,970,078.37	97.86
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>138,860,305.80</b>	<b>61,090,642.80</b>	<b>77,769,663.00</b>	<b>43.99</b>
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	20,206,310.10	20,452,729.08	(246,418.98)	101.22
310001	Улсын төсвөөс санхүүжих	20,206,310.10	20,452,729.08	(246,418.98)	101.22
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	118,653,995.70	40,541,356.21	78,112,639.49	34.17
330001	Нийгмийн даатгалын сангаас	118,653,995.70	40,541,356.21	78,112,639.49	34.17

	санхүүжих				
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>0.00</b>	<b>96,557.51</b>	<b>(96,557.51)</b>	<b>0.00</b>
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	96,557.51	(96,557.51)	0.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	8,658,671.78	(8,658,671.78)	0.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	10,412,757.89	(10,412,757.89)	0.00
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1.00</b>	<b>1.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	0.00	100.00

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 12,477.5 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 12,477.5 мянган төгрөгийн 2 алдааг залрууллаа.

Залруулсан алдаа:

- ✓ Төлбөртэй үйлчилгээний авлагыг 9,477.5 мянган төгрөгөөр дутуу бүртгэснийг аудитын явцад залруулж, авлагын үлдэгдлийг нэмэгдүүлж бүртгүүлээ.
- ✓ Санхүүгийн тайлан дахь авлагын дансны тодруулгаар Э тайланд 3,000.0 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй авлагын үлдэгдлээр бүртгэснийг аудитын явцад залрууллаа.

Энэ нь УСНББОУС 1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4, 14.4.2, 15.1, 15.2 дахь заалт болон аудитын тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул авлагын тайланд залруулга хийлгэлээ.

Аудитаар нийт 5,617.3 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрсэнд зөрчлийг таслан зогсоож, арилгуулах 2 албан шаардлага хүргүүлээ.

Архангай аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2024 оны тайланг Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасан цаглаварт хугацаанд ирүүлээгүйд 2024.03.11-ний өдрийн 187 дугаар албан бичгээр аудитын дүгнэлт гаргах, хангалттай зохистой нотолгоо олж авахад хязгаарлалт үүсгэж байгааг мэдэгдэж, зөрчлийг арилгаж санхүүгийн тайланг яаралтай ирүүлэх санал хүргүүлсэн.

**2024 онд Нийгмийн даатгалын ерөнхий газраас нэвтрүүлсэн “ SICOS” системийн нэвтрүүлэлт, хөгжүүлэлттэй холбоотойгоор сангийн тайланг программаар бэлтгэн боловсруулах ажил удаашралтайгаас тайлан хуулийн хугацаанд бэлтгээгүй байна.**

Энэхүү цаг хугацааны хязгаарлагдмал байдал нь нийгмийн даатгалын сангийн тайланд тусгагдсан 135,911,737.1 мянган төгрөгийн тэтгэвэр, тэтгэмжийн зардлыг материаллаг алдаагүй, үнэн зөв илэрхийлсэн талаар аудитын хангалттай зохистой, нотлох зүйл олж авах боломжгүй байх тул илрүүлээгүй буруу илэрхийллийн санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөө материаллаг байж болох боловч өргөн тархаагүй тул **Хязгаарлалттай дүгнэлт** өглөө.

### 5.1 Албан шаардлага

5.1.1 Архангай аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн гүйцэтгэл санхүүгийн тайланг Төсвийн тухай хуульд заасан цаглаварт хугацаанд ирүүлээгүй, цаг хугацааны хязгаарлалтад оруулж, тайланд тусгагдсан 135,911,737.1 мянган төгрөгийн тэтгэвэр, тэтгэмжийн зардлыг материаллаг алдаагүй, үнэн зөв илэрхийлсэн талаар

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхиуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

аудитын хангалттай зохистой, нотлох зүйл олж авах боломжгүй, аудитыг хуулийн хугацаанд чанартай гүйцэтгэх, санхүүгийн тайланд дүгнэлт гаргах нөхцөлөөр хангаагүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д “төсвийн төвлөрүүлэн захирагч ... жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг дараа оны 3 дугаар сарын 05-ны өдрийн дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг жил бүрийн 3 дугаар сарын 25-ны өдрийн дотор төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх”, 15 дугаар зүйлийн 15.4.1-д “төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8–д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх”, 16 дугаар зүйлийн 16.5.7-д “байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах” гэсэн заалтыг зөрчиж байна.

**Шийдвэрлэсэн нь:** Зөрчлийг таслан зогсоож, санхүүгийн тайланг хуульд заасан хугацаанд гаргаж Төрийн аудитын газарт ирүүлж аудит хийлгэх арга хэмжээ авч ажиллах албан шаардлага хүргүүлэв.

5.1.2 Тайлант онд 3 дээш жилийн насжилттай нийт 5,617.3 мянган төгрөгийн авлагыг барагдуулах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж, авлага өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Хугацаатай хэтэрсэн авлагыг барагдуулах тодорхой арга хэмжээг авч, сумдын удирдлагуудад үүрэг чиглэл өгч, биелэлтийг тооцон ажиллах албан шаардлагыг хүргүүллээ.

*Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох  
ажилтнуудад талархал илэрхийлье.*

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Авлагыг дутуу бүртгэсэн	1	9,477.5	-	-	1	9,477.5	1	9,477.5	-	-	-	-
Тооцоо нийлж баталгаажуул аагүй авлагаар бүртгэсэн	1	3,000.0	1	3,000.0			1	3,000.0				
Нийт дүн	1	12,477.5	1	3,000.0	1	9,477.5	2	12,477.5				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Авлагатай холбоотой	1	5,617.3	-	-	1	5,617.3	-	-	-	-	-	-
Тайлангийн хуулийн хугацааг мөрдөж ажиллаагүйтэй холбоотой	1	-	-	-	1	-	-	-	-	-	-	-
НИЙТ ДҮН	2	5,617.3	-	-	2	5,617.3	-	-	-	-	-	-

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
-	-	-	-	-	-	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
-	-	-	-	-	-	-	-	-